

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГСА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Б.Дарханбат Ахлах аудитор Б.Анхтуяа Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот 2023 оны 04 дүгээр сар	Төсвийн орлогын төлөвлөлт өмнөх жилүүдээс сайжирсан боловч зардлын төлөвлөлтөд тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжийг дагаж мөрдөөгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна. 7 1.1. ТЕЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжаар хориглосон “автомашин худалдан авах” арга хэмжээ төлөвлөсөн байна.7 1.2. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас хянасан хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна.10 Орлогын төлөвлөгөө дуудлага худалдааны орлогоос шалтгаалан нийт дүнгээрээ 5%-иар давж биелсэн байна. 12 2.1 Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 5% буюу 409.4 сая төгрөгөөр давж биелсэн боловч 9 нэр төрлийн татварын орлого 685.3 сая төгрөгөөр тасарсан байна.12 2.2 Хууль эрх зүйн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй 64.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн боловч огт орлого төвлөрүүлээгүй байна.15 2.3 “Цөм сүргийн үржлийн төв”-ийн өөрийн орлогын төлөвлөгөө 21.1 сая төгрөгөөр тасарсан, зөрчил жил бүр давтагдсаар байна.16 2.4 2022 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 236.6 сая төгрөгөөр буурсан байна.17 2.5 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжсэн байна.17 2.6 Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.17 Төсвийн зарлагын гүйцэтгэл 85%-тай, нийт хэмнэлтийн 32 хувь буюу 941.3 сая төгрөгийн бодит бүс хэмнэлт байна. 18 3.1 Аймгийн ЗДТГ, ИТХ-ын суурь зарлагыг төсвийн хязгаараас жил бүр нэмэгдүүлэн баталдаг, ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчил буурахгүй байгаа нь төсөв үр ашигтай зарцуулагдахгүй байгааг харуулж байна.18 3.2 Төсвийн хэмнэлтийн 2,906.5 сая төгрөгийн 32% буюу 941.3 сая төгрөг бодит бүс хэмнэлт байна.20 3.3 Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.21 Төсөв захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг чанарын үзүүлэлтээр үнэлээгүй байна. 22 4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 97.1 хувьтай байна.22 4.2 ТЕЗ-ийн харьяанд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшнийг тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөж, хэрэгжилтийг бодитой үнэлэх шаардлагатай байна.24 Дүгнэлт Зөвлөмж
--	--

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМХТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамирын спортын газар
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДНС	Засаг даргын нөөц сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2022 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
2. 2022 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
3. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль,
4. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Нийгмийн даатгалын багц хуулиуд
6. Төрийн аудитын тухай хууль
7. Төрийн хэмнэлтийн тухай хууль
8. Татварын багц хуулиуд
9. Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
10. Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Аудитын хамарсан
хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа мэдээлэл болон бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 1000-1800, Төрийн хяналт шалгалтын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл:

Хүний нөөцийн хүрэлцээгүй байдлын улмаас аудиторуд цаг хугацааны хувьд давхардалтай 3 аудитад зэрэг ажилласан нь хүндрэл бэрхшээл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 19,254.0 сая төгрөг батлагдсанаас нийт зардлын гүйцэтгэл 16,347.5 сая төгрөг буюу 85 хувьтай байна.

Тайлант онд нийт 2,906.5 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Үүнээс:

1. 34 байгууллагын 788.5 сая төгрөгийн үлдэгдэл нь бодит хэмнэлт бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал, төрийн өмчит байгууллагад олгох татаас урсгал шилжүүлэг зэрэг зардлууд хэмнэгдсэн байна.
2. Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 1,176.7 сая төгрөгийн төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдээгүй он дамжсан.
3. 941.3 сая төгрөгийн хэмнэлт нь бодит бус хэмнэлт бөгөөд байгууллагаар нь харуубал:
 - ЦСҮТ ОНӨҮГ нь орлогын төлөвлөгөөг 21.1 сая төгрөгөөр тасалснаас холбогдох зардлыг санхүүжүүлээгүй.
 - Аймаг сумдын ОНХС-гийн ажил төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй болон он дамжсанаас 778.5 сая
 - Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжээгүй ажлын санхүүжилт 25.0 сая
 - Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын хэрэгжээгүй ажлын үлдэгдэл 116.7 сая

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	14
Дүрслэл 2	2022 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгаа	18

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	УИХ-аас батлагдсан 2022 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт	7-8
Хүснэгт 2	2022 оны батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан судалгаа	9-10
Хүснэгт 3	УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсөв	11
Хүснэгт 4	Аймгийн 2022 оны тодотгосон төсөв	12
Хүснэгт 5	2021 оны тэнцлийн ашиг аймаг, сумдаар	13
Хүснэгт 6	ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардал	13
Хүснэгт 7	2022 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	14
Хүснэгт 8	2022 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэр, төрөл	14-15
Хүснэгт 9	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 10	Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	17
Хүснэгт 11	2022 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгаа	17
Хүснэгт 12	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	19
Хүснэгт 13	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	20
Хүснэгт 14	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	20
Хүснэгт 15	Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн зардлын зүйл анги	23
Хүснэгт 16	Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	25

БҮЛЭГ 1

Төсвийн орлогын төлөвлөлт өмнөх жилүүдээс сайжирсан боловч зардлын төлөвлөлтөд тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжийг дагаж мөрдөөгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна.

1.1. ТЕЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжаар хориглосон “автомашин худалдан авах” арга хэмжээ төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдаж, Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4-1/6372 тоот албан бичгээр УИХ-аас батлагдсан төсвийг ирүүлсэн байна.

Сангийн яамнаас баталсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг зөрчиж аймгийн Засаг даргын албан тушаалын автомашин худалдан авахаар 300.0 сая төгрөгөөр төлөвлөж, АИТХ-аар баталсныг Сангийн яамнаас хориг тавьсан байна.

2022 онд Говьсүмбэр аймгийн төсвийн суурь орлогыг 7,026.6 сая, суурь зарлагыг 9,304.0 сая төгрөгөөр хянасныг нэмэгдүүлэн төлөвлөж, АИТХ-аар батлуулсан байна.

Төсөв захирагч нь төсвийн орлого, зарлагыг өмнөх онуудын гүйцэтгэл, байгууллагуудын саналд үндэслэн төлөвлөдөг байна.

УИХ-аар батлагдсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн 2022 оны төсвийн нийт зарлагыг 12,798.5 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- Төсвийн суурь зарлага 9,304.0 сая
- ОНХС-ийн зарлага 3,494.5 сая

Аймгийн ИТХТ-ийн 2021.12.03-ны өдрийн 05, Сүмбэр сумын ИТХ-ын 2021.12.20-ны 05, Шивээговь сумын 2021.12.17-ны 10, Баянтал сумын 2021.12.20-ны 06 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 10,613.4 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 2,192.5 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 4,075.6 сая, сумдын СХС-гийн зарлагыг 545.9 сая, нийт 17,427.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн 2022 оны төсвийг батлахдаа УИХ-аас баталсан төсвийг 4,628.9 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгийн ИТХТ-ийн 2022.06.20-ны өдрийн 08, Сүмбэр сумын ИТХ-ын 2022.07.07-ны 06, Шивээговь сумын 2022.07.26-ны 08, Баянтал сумын 2022.06.29-ны 05 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 352.0 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 1,395.6 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 83.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Баянтал сумын СХС-гийн зарлагыг 4.2 сая төгрөгөөр бууруулж, нийт 19,254.0 сая төгрөгөөр баталсан байна.

2022 оны орон нутгийн төсвийн орлого төлөвлөлтийн талаар:

2022 онд УИХ-аас анх батлагдсан 7,026.6 сая, тодотголоор батлагдсан 6,976.5 сая төгрөгийн орлогыг аймаг, сумдын ИТХ-аар 2,188.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлого 9,165.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлуулсан байна.

УИХ-аас батлагдсан 2022 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Орлогын нэр төрөл	УИХ-аас баталсан орлого	Аймаг, сумдын ИТХ-аас баталсан орлого	Зөрүү
1	3	4	5=4-3
Татварын орлого	6,284.9	8,118.0	1,833.1
Татварын бус орлого	691.6	1,046.9	355.3
НИЙТ ДҮН	6,976.5	9,165.0	2,188.5


Хүснэгтээс харахад: УИХ-аас батлагдсан орлогын дүнг аймгийн ИТХ-ын тогтоолоор 31.4% буюу 2,188.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал, Орон нутгийн татварын орлогыг 1,833.1 сая төгрөгөөр буюу 29.2%-аар, татварын бус орлогыг 51.3% буюу 355.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөж баталсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөнд 9 нэр, төрлийн орлогыг 1,776.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3 нэр, төрлийн орлогыг 21.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Нэмэгдүүлэн баталсан орлогыг
нэр, төрлөөр нь харуулбал:



Бууруулан баталсан орлогыг
нэр, төрлөөр нь харуулбал:



Орлого нэмэгдүүлж төлөвлөсөн шалтгааныг тодруулбал:

- Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогыг аймгийн Татварын хэлтсийн 2022 оны №02/40 дугаар албан бичгээр ирүүлсэн өрийн судалгаа, Шивээ-овоо ХК-ийн татварын өрийн жагсаалтад үндэслэсэн
- Хөрөнгө борлуулсны орлогыг 2021 оны орлогын гүйцэтгэлд үндэслэсэн
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж, ТАБ-аас өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу 2023 онд татварын хувь хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалсан
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Сүмбэр, Баянтал сумын ИТХ-аар хэлэлцүүлж нэмэгдүүлсэн
- Газрын төлбөрийг аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн өрийн үлдэгдэлд үндэслэсэн
- Дуудлага худалдааны орлогыг хагас жилийн байдлаарх гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн Шивээ-овоо ХК-ны татварын үлдэгдлийн жагсаалтад үндэслэсэн
- Малд ногдуулах албан татварыг Татварын хэлтсээс ирүүлсэн саналд үндэслэсэн

Орлого бууруулж төлөвлөсөн шалтгааныг тодруулбал:

- Хөрөнгийн орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийг Баянтал сумын ИТХ-аар хэлэлцүүлж бууруулсан, улсын тэмдэгтийн хураамжийн орлого нь

нарийвчлан төлөвлөхөд хүндрэлтэй орлого бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар тасрах магадлалтай байсан гэсэн тайлбарыг ирүүлсэн.

ААНОАТ-ын төлөвлөлтийн талаар:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д зааснаар аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь төвлөрдөг болсон ба Сангийн сайдын 2022 оны А/7 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу ААНОАТ-ын орлогоос орон нутагт хуваарилсан байна.

Аймгийн Татварын хэлтсээс албан бичгээр ирүүлсэн судалгаанд ААНОАТ-ыг Сангийн яам 400.0 сая төгрөгөөр хянаж, түүний 40 хувь буюу 160.0 сая төгрөг орохоор төлөвлөжээ. Тус төлөвлөлтийн талаар аймгийн Татварын хэлтсээс тодруулахад Шивээ-овоо ХК-ны үнийг чөлөөлж, алдагдалгүй ажиллана гэсэн төсөөллөөр Сангийн яам төлөвлөсөн гэж хариу ирүүлсэн байна.

Татварын бус орлогын төлөвлөгөөнд 3 нэр төрлийн орлогыг 355.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого - 51.0 сая

Хүү, торгуулийн орлого - 240.3 сая

Бусад орлого - 64.0 сая

• Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг Усан спорт сургалтын төв 18.0 сая, авто замын сан 20.0 сая, СДОА 13.0 сая, нийт 51.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн

• Хүү, торгуулийн орлогыг орлогын нэр төрөл бүрээр төлөвлөөгүй, 2021 оны гүйцэтгэлд үндэслэн 240.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн

• Шивээговь сум нь хууль эрх зүйн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй 64.0 сая төгрөгийн бусад орлогыг төлөвлөсөн

2022 оны батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2021 оны батлагдсан орлого	2022 оны батлагдсан орлого	Зөрүү
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	3,780.0	5,171.6	-1,391.6
2	ХХОАТ-ын буцаан олголт	-174.4	-263.9	-89.5
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	440.0	740.0	-300.0
4	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	120.0	130.0	-10.0
5	Улсын тэмдэгтийн хураамж	141.1	111.2	29.9
6	Газрын төлбөр	350.0	389.0	-39.0
7	Ус ашигласны төлбөр	400.0	581.0	-181.0
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	20.0	-20.0
9	Дуудлага худалдааны орлого	268.0	10.0	258.0
10	Хөрөнгийн орлого	211.5	248.0	-36.5
11	Хөрөнгө борлуулсны орлого	45.5	150.0	-104.5
12	Шууд бус орлого	205.2	300.0	-94.8
13	Үйл ажиллагааны орлого	82.1	40.0	42.1
14	Бууны албан татвар	5.0	4.9	0.1
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24.0	20.0	4.0
16	Хог хаягдлын хураамж	119.0	162.0	-43.0
17	Малд ногдуулах албан татвар	-	144.2	-144.2
18	ААН-ийн орлогын албан татвар	-	160.0	-160.0

Татварын орлогын нийт дүн		6,017.0	8,118.0	2,101.0
1	Түрээсийн орлого	60.0	60.0	-
2	Хүү, торгуулийн орлого	564.0	840.3	-276.3
3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	51.6	82.6	-31.0
4	Бусад орлого	-	64.0	-64.0
5	Сумдын СХС орлого	359.0	126.5	232.5
Татварын бус орлогын нийт дүн		1,034.6	1,173.4	138.8

Хүснэгтээс харахад: Өмнөх онтой харьцуулахад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 31.8% буюу нийт 2,239.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.2. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас хянасан хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна.

2022 оны орон нутгийн төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

Аймгийн 2022 оны төсвийн нийт зарлага 12,798.5 сая төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Үүнд: орон нутгийн суурь зарлага 9,304.0 сая, ОНХС-ийн зарлага 3,494,5 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022 оны төсвийг батлуулахдаа УИХ-аас баталсан төсвийн суурь зардлыг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 4,628.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

Д/д		2021 онд батлагдсан төсөв		Зөрүү
		УИХ-аар батлагдсан	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн баталсан	
1	Орон нутгийн суурь зарлага	9,304.0	10,613.4	1,309.4
2	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	3,494,5	4,075.6	581.1
3	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	0.0	2,192.5	2,192.5
4	Сумдын СХС-гийн зарлага	0.0	545.9	545.9
Нийт дүн		12,798.5	17,427.4	4,628.9

Хүснэгтээс харахад: Сангийн яамнаас хянасан төсвийг 36.17% буюу нийт 4,628.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Зардлыг нэмэгдүүлэхдээ дараах байгууллагуудын урсгал зардлаас нийт 714.2 сая төгрөгийг хассан байна. Үүнд:

- Хот тохижилтын зардлаас 181.1 сая,
- Орон нутгийн өмчийн байгууллагуудын тогтмол зардал, завсар үйлчилгээний зардлаас 533.1 сая.

Нэмэгдүүлж баталсан зардлыг байгууллагаар нь авч үзвэл:

1. Орон нутгийн суурь зарлагыг нийт 2,023.4 сая төгрөгөөр. Үүнд:

- Аймгийн ИТХ-д 192.8 сая,
- Аймгийн ЗДТГ-т 222.9 сая,
- Аймгийн ЗД-ын хэрэгжүүлэх арга хэмжээнд 542.0 сая,
- ОНӨГ-т 20.0 сая,
- Автозамын санд 102.2 сая,
- Сум дундын ойн ангид 30.0 сая
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 18.0 сая
- Насан туршийн боловсролын төвд 70.0 сая

- Сүмбэр сумын ИТХ 31.8 сая, ЗДТГ 299.6 сая,
- Баянтал сумын ИТХ 19.5 сая, ЗДТГ 117.1 сая,
- Шивээговь сумын ИТХ 41.0 сая, ЗДТГ 236.5 сая
- Биеийн тамир спортын газарт 80.0 сая,
- 2. **Аймаг, сумдын ОНХС-ийн зарлагыг нийт 581.1 сая төгрөгөөр. Үүнд:**
 - Аймгийн ОНХС 72.0 сая,
 - Сүмбэр сумын ОНХС 411.3 сая,
 - Шивээговь сумын ОНХС 64.7 сая,
 - Баянтал сумын ОНХС 33.1 сая
- 3. **Орон нутгийн хөрөнгө оруулалт 2,192.5 сая төгрөгөөр**
- 4. **Сумдын СХС-гийн зарлагыг нийт 545.9 сая төгрөгөөр. Үүнд:**
 - Сүмбэр сумын СХС 408.5 сая,
 - Шивээговь сумын СХС 30.7 сая,
 - Баянтал сумын СХС 106.7 сая,

Тайлант онд төсвийн тодотгол хийж аймгийн ИТХТ-ийн 2022.06.20-ны өдрийн 08, Сүмбэр сумын ИТХ-ын 2022.07.07-ны 06, Шивээговь сумын 2022.07.26-ны 08, Баянтал сумын 2022.06.29-ны 05 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 352.0 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 1,395.6 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 83.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Баянтал сумын СХС-гийн зарлагыг 4.2 сая төгрөгөөр бууруулж, нийт 19,254.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2022 оны тодотгосон төсвийг хүснэгтээр харуулбал

Хүснэгт №4		/сая төгрөгөөр/		
Д/д	Зардлын төсөв	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
1	Орон нутгийн суурь зарлага	10,613.4	10,951.3	337.5
2	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	4,075.6	4,164.8	89.2
3	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	2,192.5	3,587.8	1,395.3
4	Сумдын СХС-ийн зарлага	545.9	550.1	4.2
Нийт дүн		17,427.4	19,254.0	1,826.2

Хүснэгтээс харахад батлагдсан төсвийг 1,826.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

1. *Орон нутгийн суурь зарлагыг нийт 337.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнд: Аймгийн ИТХ-240.3 сая, АЗДТГ-165.9 сая, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ 81.0 сая, СДОА 44.3 сая, БТСГ 30.0 сая, Боржигин чуулгын байр ашиглалтын зардал 5.5 сая, Насан туршийн боловсролын төв 8.1 сая, Сүмбэр сумын ЗДТГ 22.4 сая, Шивээговь сумын ИТХ 3.9 сая, ЗДТГ 35.0 сая, Баянтал сумын ИТХ 13.7 сая, ЗДТГ 33.4 сая, Политехник коллеж, ЕБС-ийн байр ашиглалтын зардал 213.7 сая нийт 897.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ЦСҮТ, ОНӨГазар, Ахмадын хороо, БОАЖГ, СХДАА-наас 9.6 сая, Малын вакцин, Хүн тээврийн зардлаас 0.6 сая, СӨББ -ийн байр ашиглалтын тогтмол зардлаас 117.0 сая, Эрүүл мэндийн байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлаас 432.4 сая, нийт 559.6 сая төгрөгөөр бууруулсан.*
2. *Аймаг, сумын ОНХС-г 89.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнд: Аймгийн ОНХС 36.1 сая, Сүмбэр сумын ОНХС 97.5 сая, нийт 133.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Баянтал сумын ОНХС 0.5 сая, Шивээговь сумын ОНХС-г 43.7 сая, нийт 44.2 сая төгрөгөөр бууруулсан.*
3. *Орон нутгийн хөрөнгө оруулалт 1,395.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.*
4. *Баянтал сумын СХС-гийн зарлагыг 4.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.*

1.3 Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг Шивээговь сум 13.4 сая, ОНХС-гийн эх үүсвэрийг 0.8 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2021 онд татварын орлогын төлөвлөгөөг 2,772.8 сая, татварын бус орлогын төлөвлөгөөг 578.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, орон нутгийн төсвийн байгууллагууд 1,217.2 сая төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

2021 оны тэнцлийн ашгийг аймаг, сумдаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

Д/д	Аймаг, сумдын нэр	2021 оны		Нийт дүн
		Давсан орлого	Хэмнэгдсэн зардал	
1	Аймаг	2,983.9	1,168.4	4,152.3
2	Сүмбэр сум	341.0	27.7	368.7
3	Баянтал сум	32.1	6.3	38.4
4	Шивээговь сум	23.6	14.8	38.4
Нийт		3,380.6	1,217.2	4,597.8

Хүснэгтээс харахад: 2021 онд нийт 4,597.8 сая төгрөгийн тэнцлийн ашигтай гарсан байна. Нийт тэнцлийн ашгийн 90%-ийг аймаг, 8%-ийг Сүмбэр сум, 2%-ийг Баянтал, Шивээговь сум тус тус эзэлж байна.

2021 оны тэнцлийн ашгийг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2022 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон батлахдаа Шивээговь сум 13.4 сая төгрөгөөр дутуу тодотгож баталсан байна

Өмнөх онд ОНХС-ийн ажлууд тайлант ондоо багтаж хийгдээгүй, он дамжсанаас шалтгаалан нийт 414.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Үүнд: Аймгийн ОНХС 181.5 сая, Сүмбэр сумын ОНХС 142.8 сая, Баянтал сумын ОНХС 24.6 сая, Шивээговь сумын ОНХС 66.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

/сая төгрөгөөр/

Д/д	ОНХС-гийн нэр	2021 оны ОНХС-ийн дансны үлдэгдэл	Эхний үлдэгдлээс санхүүжихээр баталсан	Зөрүү
1	Аймгийн ОНХС	193.8	193.8	0.0
2	Сүмбэр сумын ОНХС	142.6	142.6	0.0
3	Баянтал сумын ОНХС	5.8	5.8	0.0
4	Шивээговь сумын ОНХС	31.2	30.4	-0.8
Нийт дүн		373.4	372.6	-0.8

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг нийт 372.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Шивээговь сумын ОНХС нь 2022 оны төсвийг батлахдаа эх үүсвэрийг 0.8 сая төгрөгөөр дутуу баталсантай холбоотой байна.

БҮЛЭГ 2

Орлогын төлөвлөгөө дуудлага худалдааны орлогоос шалтгаалан нийт дүнгээрээ 5%-иар давж биелсэн байна.

2.1 Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 5% буюу 409.4 сая төгрөгөөр давж биелсэн боловч 9 нэр төрлийн татварын орлого 685.3 сая төгрөгөөр тасарсан байна.

2022 онд орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлогод нийт 8,118.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,527.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 409.5 сая төгрөг буюу 5%-аар давж биелсэн байна.

2022 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7

/сая төгрөгөөр/

Он	Татварын орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2022	8,118.0	8,527.5	409.5	105.0
2021	6,017.1	8,789.9	2,772.8	146.0

**Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
/2 жилээр/**



Дүрслэлээс харахад: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 35.0%-аар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба өмнөх оны гүйцэтгэлээс 3.1%-аар өссөн байна. 2021 онд орлогын төлөвлөгөө 46.0%-иар давж биелсэн бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 5%-аар давж биелсэн байна.

2022 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр, төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №8

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	5,171.6	5,459.6	-288.0	5.6
Үйл ажиллагааны орлого	40.0	98.3	-58.3	145.7
Хөрөнгийн орлого	248.0	260.8	-12.8	5.2
Хөрөнгө борлуулсны орлого	150.0	108.2	41.8	-27.9
Шууд бус орлого	300.0	368.7	-68.7	22.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-263.9	-263.9	0.0	-
ААН-ийн орлогын албан татвар	160.0	160.0	0.0	-
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	740.0	559.6	180.4	-24.4
Бууны албан татвар	4.9	4.7	0.2	-4.1
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	130.0	135.0	-5.0	3.8
Малд ногдуулах албан татвар	144.2	70.0	74.3	-51.5
Улсын тэмдэгтийн хураамж	111.2	67.9	43.3	-38.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	19.1	0.9	-4.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	162.0	188.1	-26.1	16.1
Газрын төлбөр	389.0	278.4	110.6	-28.4
Дуудлага худалдаа	10.0	645.8	-635.8	6358
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	20.0	0.0	20.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	581.0	367.2	213.8	-36.8
Нийт дүн	8,118.0	8,527.5	-409.4	5.0

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 409.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: 7 нэр төрлийн орлого 3.8 хувиас 63 дахин буюу 5.0-635.8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн бол 9 нэр төрлийн орлого 4.1-51.5%-аар буюу 0.2-213.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулбал:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогын төлөвлөгөө давсан нь Шивээ овоо ХК-ны өмнөх оны өр төлөгдсөн
- Дуудлага худалдааны орлого төлөвлөснөөс 63 дахин давж биелсэн
- Малчдын ноос, арьс ширний 2020-2022 оны урамшууллыг 2022 онд ХХААХҮЯ-аас олгосон ба орлогоос суутгасан татварыг сумдад хуваарилснаас шалтгаалан үйл ажиллагааны орлого 58.3 сая төгрөгөөр давсан

Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгааныг тодруулбал:

- Улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан ипотекийн болон орон сууцны зээл олголт хязгаарлагдсантай холбоотой иргэдийн орон сууц худалдан авах, борлуулах нь багасаж, хөрөнгө борлуулсны албан татвар тасарсан
- Шүүгчийн захирамжаар улсын тэмдэгтийн хураамжаас 53.8 сая төгрөгийг иргэд, хуулийн этгээдэд буцаан олгосон
- Өмчлөлийн талбай давхардсан газрын маргаанаас шалтгаалан газрын төлбөр төлөгдөөгүй
- Улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан усны төлбөр төлөгдөөгүй
- БОАЖЯ-аас 2 угалз агнах зөвшөөрлийг өгсөн боловч агнаагүй
- Ус, рашаан ашигласны төлбөр нь татвар төлөгчдийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан төлөгдөөгүй байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2021 он		2022		Зөрүү	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	3,780.0	4,817.5	5,171.6	5,459.6	-1,391.6	-642.1
2	ХХОАТ-ын буцаан олголт	-174.4	-174.4	-263.9	-263.9	-	-
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	440.0	536.8	740.0	559.6	-300.0	-22.8
4	АТБӨЯХ-ийн албан татвар	120.0	112.1	130.0	135.0	-10.0	-22.9
5	Улсын тэмдэгтийн хураамж	141.1	248.7	111.2	67.9	29.9	180.8
6	Газрын төлбөр	350.0	366.1	389.0	278.4	-39.0	87.7
7	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	400.0	682.7	581.0	367.2	-181.0	315.5
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	5.3	20.0	0.0	-20.0	5.3
9	Дуудлага худалдааны орлого	268.0	1,094.9	10.0	645.8	258.0	449.1
10	Хөрөнгийн орлого	211.5	279.6	248.0	260.8	-36.5	18.8
11	Хөрөнгө борлуулсны орлого	45.5	223.4	150.0	108.2	-104.5	115.2
12	Шууд бус орлого	205.2	147.3	300.0	368.7	-94.8	-221.4
13	Үйл ажиллагааны орлого	82.1	190.1	40.0	98.3	42.1	91.8
14	Бууны албан татвар	5.0	4.6	4.9	4.7	0.1	-0.1
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24.0	28.0	20.0	19.1	4.0	8.9
16	Хог хаягдлын хураамж	119.0	143.9	162.0	188.1	-43.0	-44.2
17	Малд ногдуулах албан татвар	0.0	83.3	144.2	70.0	-144.2	13.3
18	ААН-ийн орлогын албан татвар	-	-	160.0	160.0	-160.0	-160.0
Татварын орлогын нийт дүн		6,017.1	8,789.9	8,118.0	8,527.5	-2,100.9	262.4

Хүснэгтээс харахад: Татварын орлого нийт дүнгээрээ өмнөх онтой харьцуулахад 2,100.9 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ба гүйцэтгэл 262.4 сая төгрөгөөр буурсан байна. Тухайлбал: өмнөх оноос татварын 12 нэр төрлийн орлогыг 10.0-1,391.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 нэр төрлийн орлогыг 0.1-258.0 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 7 нэр төрлийн орлого 0.1-642.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 10 нэр төрлийн орлого 5.3-449.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим орлогын төлөвлөгөө өмнөх оны дүнгээс давж биелсэн нь урьд оны өр төлбөр төлөгдсөнөөс шалтгаалсан байна. Тухайлбал: Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 323.6 сая /Шивээ овоо ХК-ны өмнөх оны өр төлбөр барагдуулсан/

2.2 Хууль эрх зүйн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй 64.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн боловч огт орлого төвлөрүүлээгүй байна.

2022 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 691.6 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 1,173.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 481.9 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10

/сая төгрөгөөр/

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2021	1,311.8	1,388.5	105.8
2022	1,173.5	1,280.3	109.1

Хүснэгтээс харахад: 2022 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 10.5% буюу 138.3 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд гүйцэтгэлээр тайлант оны орлогын төлөвлөгөөг 9.1%-аар давуулан биелүүлсэн байна.

2022 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын бус орлого		964.3	937.0	27.3
2.1.	Хүү, торгуулийн орлого	840.3	870.1	-29.8
2.2.	Түрээсийн орлого	60.0	42.0	18.0
2.3	Бусад орлого	64.0	24.9	39.1


Хүснэгтээс харахад татварын бус орлого нийт дүнгээрээ 11.8 сая төгрөгөөр давж биелсэн боловч түрээсийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Тухайлбал, хүү, торгуулийн орлого 29.8 сая төгрөгөөр давж биелсэн бол түрээсийн орлого 18.0 сая буюу 30%-аар тасарсан байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэж төлөвлөдөгтэй холбоотой, түрээсийн орлого биелээгүй нь “Чойр хайрхан” ХХК түрээсийн өр төлбөрөө барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Харин Шивээговь сум нь хууль эрх зүйн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй 64.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн боловч огт орлого төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.1-т “орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг”, 23.9.2-т “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9.3-т “хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2022 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгааг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №2



Дүрслэлээс харахад: Өмнөх онтой харьцуулахад төсөвт газрын өөрийн орлого, цагдаагийн хэлтсийн хүү торгуулийн орлого, бусад нэр заагдаагүй орлого 46.3-187.8 сая төгрөгөөр тус тус буурсан, МХГ-ын орлого 33.0 сая, татварын хяналт, торгуулийн орлого 3.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2.3 “Цөм сүргийн үржлийн төв”-ийн өөрийн орлогын төлөвлөгөө 21.1 сая төгрөгөөр тасарсан, зөрчил жил бүр давтагдсаар байна.

2022 онд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 31.6 сая төгрөгөөр баталсан ба аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 51.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 82.6 сая төгрөгөөр батлуулсан байна. Автозамын сангийн орлогыг 20.0 сая, Усан спорт сургалтын төвийн орлогыг 18.0 сая, СДОА-гийн орлогыг 13.0 сая төгрөгөөр нэмж батлуулсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2022 он		2021 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	АЗДТГ	0.7	17.9	0.7	2.1
2	УССТ	18.0	18.7		
3	Цөм сүрэг үржлийн төв ОНӨҮГ	30.9	9.8	30.9	26.3
4	Авто зам	20.0	21.7	20.0	49.6
5	СДОА	13.0	13.0		
Дүн		82.6	81.1	51.6	78.0
Сумдын сангийн орлого					
1	Сумдын сум хөгжүүлэх сан	126.5	262.2	359.0	386.1
Дүн		126.5	262.2	359.0	359.0
НИЙТ ДҮН		209.1	343.3	410.6	464.1

Хүснэгтээс харахад: 2022 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 50.9%-аар буюу 201.5 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна. Энэ нь Сумдын сум хөгжүүлэх сангуудын орлогыг тухайн жилийн зээлийн эргэн төлөлтөд уялдуулж төлөвлөсөнтэй холбоотой юм.

Өөрийн орлогын төлөвлөгөө нийт 134.2 сая төгрөг буюу 64.2%-аар давж биелсэн байна. Тухайлбал: АЗДТГ 17.3 сая, Авто замын сан 1.7 сая, Усан спорт сургалтын төв 0.7 сая, Сумдын Сум хөгжүүлэх сангуудын орлого 135.6 сая, нийт 155.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

АЗДТГ-ын 16.5 сая төгрөгөөр давсан орлого нь аймгийн баяр наадмаар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосонтой холбоотой төлөвлөгдөөгүй орлого төвлөрүүлсэн байна.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь өөрийн орлогын төлөвлөгөөг 21.1 сая төгрөгөөр биелүүлээгүй ба жил бүр зөрчил давтагдсаар байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.4 2022 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 236.6 сая төгрөгөөр буурсан байна.

2022 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг анх 2,277.4 сая төгрөгөөр батлагдсан боловч төсвийн тодотголоор 900.9 сая төгрөгөөр бууруулж, 1,376.5 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №13

/сая төгрөгөөр/

Он	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2022	1,376.5	1,376.5	-
2021	1,613.1	1,613.1	-

Тус аймаг нь 2021 онд улсын төсвөөс 1,613.1 сая, тайлант онд улсын төсвөөс 1,376.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба өмнөх онтой харьцуулахад 14.7%-аар буурсан байна.

2.5 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжсэн байна.

2022 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгт дотоодын газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь, АМНАТ-ийн хуваарилалт 10 хувь, АМХТЗ-ийн 100 хувь, АМАТЗ-ийн 50 хувь, ОУБ-аас сумдын ОНХС-д олгох урамшуулал, нийт 3,205.1 сая төгрөгөөр батлагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №14

/сая төгрөгөөр/

Он	ОНХНС-ийн санхүүжилт			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2022	3,205.1	3,205.1	0.0	100
2021	1,558.0	1,558.0	0.0	100

Хүснэгтээс харахад: 2022 онд ОНХНС-аас олгох санхүүжилт өмнөх оноос 105.7%-аар нэмэгдэж батлагдсан ба гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авсан байна.

2.6 Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

2021 онд татварын болон татварын бус давсан орлогоос нийт 3,350.6 сая, орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэн нийт 1,217.2 сая /аймаг 1,168.4 сая, Сүмбэр сум 27.7 сая, Баянтал сум 6.3 сая, Шивээговь сум 14.8 сая/, нийт 4,597.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 3

Төсвийн зарлагын гүйцэтгэл 85%-тай, нийт хэмнэлтийн 32 хувь
буюу 941.3 сая төгрөгийн бодит бус хэмнэлт байна.

3.1 Аймгийн ЗДТГ, ИТХ-ын суурь зарлагыг төсвийн хязгаараас жил бүр нэмэгдүүлэн баталдаг, ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчил буурахгүй байгаа нь төсөв үр ашигтай зарцуулагдахгүй байгааг харуулж байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх нийт 22 хөтөлбөрт зориулан 19,254.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 11,676.1 сая төгрөгийг урсгал зардалд, 7,027.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 550.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой нийт 415.3 сая төгрөгийн дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Тухайлбал:

1. УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн зарлагыг аймаг, сумдын ИТХ-аар батлахдаа тухайн жилийн төсвийн зарлагын талаар баримтлах бодлого, чиглэл, төсвийн хэмнэлтийн горимыг баримтлаагүйгээс суурь зарлагыг нийт 415.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. /Аймгийн ИТХ-ын төсвийн урсгал зардалд 208.2 сая, ГХУСАХЗ-д 41.1 сая аймгийн ЗДТГ-ын урсгал зардалд 166.0 сая/

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал зардалтай холбоотой зарим зардлын өсөлт нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Насан туршийн боловсролын төвийн батлагдсан орон тоо Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдсэн байна. Орон тоог хязгаараас нэмэгдүүлж баталдаг асуудал урд онуудад мөн гарч байсныг төсвийн төсөлд өгсөн саналуудад жил бүр тусгаж байсан. Энэ нь орон нутаг төсвөө хязгаарт багтаах тухай хуулийн заалтад нийцүүлэн боловсруулахгүй байгаатай холбоотой ч, Сангийн яам орон тоог бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцохгүй байгаа нь мөн нөлөөлж байна.
2. Орон нутгийн өмчийн газрын орон тоог Сангийн яамнаас хянасан орон тооноос 2-оор нэмснээс шалтгаалж цалингийн зардал 20.0 сая төгрөгийг нэмж баталсан.
3. Аймгийн ИТХ-ын урсгал зардлыг /намын суудлын мөнгө - Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох ямар нэгэн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй / 17.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
4. Усан спорт сургалтын төв, Сум дундын ойн ангийн цалин санг Сангийн яаманд хянагдаагүй тул 110.0 сая төгрөгөөр баталсан.
5. Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал Сангийн яаманд хянагдаж батлагдаагүй тул 542.0 сая төгрөгөөр баталсан.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8¹, 4.1.30², 6 дугаар зүйлийн 6.4.1³, дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

¹ 4.1.8. "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

² 4.1.30. "орон нутгийн төсвийн суурь зарлага" гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг болон орон нутгийн чиг үүрэг, төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг;

³ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой нийт 683.2 сая төгрөгийн зөрчил илэрч алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Орлогын төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой:

1. Баянтал сум-Татварын орлогын төлөвлөгөөг 7.9 сая төгрөгөөр биелүүлээгүй, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй.
2. Шивээговь сум- Татварын орлогын төлөвлөгөөг 281.2 сая төгрөгөөр биелүүлээгүй, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй. АИТХ-ын тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 459.4 сая төгрөгөөр баталснаас 175.0 сая төгрөгийн төвлөрүүлж, төвлөрүүлэх орлогыг 284.4 сая төгрөгөөр тасалсан. Тайлант оны эцэст сумын төсөвт байгууллагуудаас 91.2 сая төгрөгийг хэмнэлтээр буцаан төвлөрүүлсэн нь зардлын санхүүжилтийг орлоготой уялдуулан хуваарилаагүй, аймагт төвлөрүүлэх боломжтой орлогыг төвлөрүүлээгүй, тооцоолол судалгааг үндэслэлтэй тооцоогүй. Сумын татварын бус орлогыг төлөвлөхдөө бусад орлого гэсэн төрлөөр 64.0 сая төгрөгийг төлөвлөж баталсан боловч гүйцэтгэлээр орлого төвлөрөөгүй.

Зардлын зарцуулалттай холбоотой:

1. Сүмбэр сум-Орон нутгийн өмчийн байр ашиглалт зардлаас Сумын ИТХ-ын төсвийг 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй.
2. Шивээговь сум- 12 дугаар сард 3 дугаар сургуулийн зарцуулах эрхийг илүү нээснээс санхүүжилтийг 17,159.0 мянган төгрөгөөр илүү олгож, оны эцэст буцаан төвлөрүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

Аймгийн төсөвт тодотгол хийж төсөвт байгууллагын санхүүжилтийг 6 хувиар бууруулсан байна. Энэ хуулийн хүрээнд тэвчиж болох эд хогшлын зардлыг-11.9 сая, дотоод албан томилолтын зардлыг 10.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад бараа ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг-68.6 сая, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг-116.6 сая, Засаг даргын нөөц хөрөнгийг-74.2 сая, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг-39.2 сая, нийт 320.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад 6 байгууллагаас 33.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дахь заалтад заасан мэдээллийг ил тод мэдээлээгүй тул зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.
2. Баянтал сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.2, 15.2.6 дахь заалтыг зөрчиж орон тоо, төсөв батлагдаагүй байхад 3 албан хаагчид ажил хавсарсны нэмэгдэл 5.6 мянган төгрөгийг олгосон тул зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.
3. Баянтал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3-т заасныг зөрчиж 15 төлөөлөгчдөд 0.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон тул буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.
4. Баянтал сумын ОНХС-гаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.7-т заасныг зөрчиж 0.04 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.
5. Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т заасныг зөрчиж 1.3 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг шаардлагагүйгээр нөөцөлсөн.
6. Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т заасныг зөрчин Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас МУЗЗНДНТҮТХуульд заасан чиг үүрэгт хамааралгүй арга

хэмжээнд 25.5 сая төгрөг зарцуулсан тул алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна.

3.2 Төсвийн хэмнэлтийн 2,906.5 сая төгрөгийн 32% буюу 941.3 сая төгрөг бодит бус хэмнэлт байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 19,254.0 сая төгрөг батлагдсанаас 16,347.5 сая төгрөгийг зарцуулж 2,906.5 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнасан байна. Үүнээс 941.3 сая төгрөгийн хэмнэлт нь бодит бус хэмнэлт байна.

- ЦСҮТ ОНӨҮГ нь орлогын төлөвлөгөөг 21.1 сая төгрөгөөр тасалснаас холбогдох зардлыг санхүүжүүлээгүй.
- Аймаг сумдын ОНХС-гийн ажил төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй болон он дамжсанаас 778.5 сая
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжээгүй ажлын санхүүжилт 25.0 сая
- Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал, хэрэгжээгүй ажлын үлдэгдэл 116.7 сая

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар хүснэгтээр харуулбал: Хүснэгт 15

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,254.0	16,347.5	2,906.5
УРСГАЛ ЗАРДАЛ	11,676.1	10,452.5	1,223.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,735.0	9,832.1	902.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,080.1	2,864.2	15.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	347.9	304.3	3.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,210.6	3,035.7	74.8
Хангамж, бараа материалын зардал	239.7	212.8	26.9
Нормативт зардал	15.7	9.3	6.5
Эд хогшил, урсгал засварын зардал	300.8	288.8	12.0
Томилолт, зочны зардал	71.8	61.4	10.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	968.8	900.2	68.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,499.5	2,155.4	344.1
ХҮҮ	0.0	0.0	0.0
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0
ТАТААС	2.4	1.2	1.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2.4	1.2	1.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	938.8	619.3	319.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	630.7	335.7	295.0
Бусад урсгал шилжүүлэг	308.1	283.5	24.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,027.7	5,398.5	1,629.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	550.2	496.5	53.7
Сум хөгжүүлэх сан	550.2	496.5	53.7

2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлын гүйцэтгэл, хэмнэлтийн шалтгааныг харьцуулан судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал-215.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ЦСҮТөв-8.9 сая, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба-17.1 сая, ОНӨГ-28.9 сая, СДОАнги- 9.1 сая, АИТХурал- 11.9 сая, АЗДТГ- 118.8 сая, 6 дугаар цэцэрлэг- 5.3 сая, Сүмбэр сумын ЗДТГазар- 5.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд орон тоо дутуу дутуу ажилласнаас шалтгаалжээ.

2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал-174.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд Сүмбэр сумын 2 дугаар сургууль, 5 дугаар цэцэрлэг нь товлогдсон хугацаанаасаа хойшилж ашиглалтад орсноос 136.5 сая, Шивээговь сумын 3 дугаар сургуульд илүү төсөвлөгдсөн 19.6 сая, мөн сумын эрүүл мэндийн төв нь халаалтын зардлаа нэмэлт дансны орлогоосоо төлснөөс 7.3 сая төгрөг тус тус хэмнэгдсэн нь нөлөөлжээ.
3. Хангамж, бараа материалын зардал-26.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу шаардлагагүй бараа материалыг нөөц үүсгэн бэлтгээгүйтэй холбоотой.
4. Нормативт зардал-6.5 сая сая төгрөгөөр хэмнэгдсэн ба АЗДТГ 4.0 сая төгрөгийн Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 100 хувь хэмнэсэн
5. Эд хогшил, урсгал засварын зардал-11.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймгийн ЗДТГ урсгал засварын зардлыг хэмнэсэн .
6. Томилолт, зочны зардал-10.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймгийн ЗДТГ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэсэн.
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж-68.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Сүмбэр сумын ЗДТГазар-43.2 сая төгрөгийн Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазрын гэрээгээр гүйцэтгэх ажлаас хэмнэгдсэн.
8. Бараа үйлчилгээний бусад зардал-344.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь 2019 оны Автозамын сангийн хөрөнгө оруулалтын ажлыг улсын комисс хүлээн аваагүйгаас 32.2 сая төгрөгийг шилжих хөрөнгө оруулалтаар баталж төвлөрүүлсэн. БХНСАХЗардлаас 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хаялага” нуурыг түшиглэн шинээр байгуулах төрийн байгууллагуудын хариуцах мод үржүүлгийн газрын хашаа хамгаалалтын ажил” тендер шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч тендерт орж гэрээ байгуулаагүй мөн бусад ажлын гэрээний хэмнэлт зэргээс нийт 39.2 сая, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 19 арга хэмжээний хэрэгжээгүй үлдэгдэл 116.7 сая, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулагдаагүй үлдэгдэл 74.3 сая төгрөг тус тус хэмнэгдсэн.
9. Төрийн өмчит байгууллагад олгох татаас-1.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийтийн тээврийн хөнгөлөлт гүйцэтгэлээр санхүүжигддэг ба улирлын гүйцэтгэл дараа сард нэхэмжлэхээр ирэх тул хэмнэлтээр тайлагнасан байна.
10. Засгийн газрын урсгал шилжүүлэг-294.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ОНХСангийн зарим хөрөнгө оруулалтын ажлын гэрээний хэмнэлт. Мөн сумдын ОНХСанд төлөвлөгдсөн малын тоо толгойн албан татвар бүрэн төвлөрөөгүйгээс төлөвлөсөн зардлууд хэмнэгдсэн.
11. Бусад урсгал шилжүүлэг-24.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Халамжийн сангийн онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийн зардал нь хуульд заасан эрсдэл учраагүй тул 18.0 сая төгрөгийг хэмнэсэн.
12. Хөрөнгийн зардал-1,629.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Орон нутгийн хөрөнгө оруулалтын он дамжин хэрэгжих 6 ажлын 395.7 сая төгрөг, тухайн онд гэрээ байгуулаагүй болон гэрээний хэмнэлтээс 875.3 сая, аймаг, сумын ОНХС-гийн он дамжин хэрэгжих болон гэрээний хэмнэлтээс 254.9 сая төгрөгийн тус тус хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.
13. Сум хөгжүүлэх сан-53.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Шивээговь сум нь шаардлагад нийцсэн зээл авах төсөл ирээгүй тул тайлант онд зээл олгоогүй.

3.3 Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 258.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 84.2 сая, нийт 342.4 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 14.9 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 1.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 5.4 сая, хангамж, бараа материалын зардалд 6.3 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 13.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 163.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 23.0 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 40.0 сая, нийт 268.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 24.4 сая төгрөгийн орлого, байгууллагуудын зардлын давхардсан гүйлгээг устгасан байна.

Аймаг, сумдын нэмэлт төвлөрүүлэлтийн дансны эхний үлдэгдэл 0.8 сая төгрөг байсан тайлант хугацаанд үлдэгдэл тайлагнаагүй байна. АЗДТГ-ын төвлөрүүлсэн 74.1 сая төгрөгөөс 57.6 сая төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэж 16.5 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

БҮЛЭГ 4

Төсөв захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг чанарын үзүүлэлтээр үнэлээгүй байна.

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 97.1 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 08 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталсан. Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 21 хөтөлбөрт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 16 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/сая төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа,	2022	МУЗЗНДНТУТХ болон Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх	100%	509.9	483.8
2	ГХУСАХ	2022	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг бууруулна	100%	205.7	204.7
3	Засаг даргын ажлын алба	2022	Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	100%	1,566.3	1,390.4
4	Засаг даргын нөөц	2022	Сангийн сайдын тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах журам хэрэгжсэн байна.	100%	409.7	318.9
5	Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	2022	Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 19 арга хэмжээг үр дүнтэй, чанартай зохион байгуулсан байна.	100%	623.0	471.7
6	Нийтийн тээврийн хөнгөлөлт	2022	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан нийтийн тээврийн үйлчилгээг үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр хүртсэн байна.	100%	2.3	1.1
7	Авто замын сан	2022	Орон нутгийн авто замын чанар, нөхцөл сайжирна.	93.4%	493.2	460.5
8	Ахмадын хороо	2022	Ахмад настны нийг-мийн халамж, хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, ахмадуудын хөдөлмөр	100%	52.9	52.9

			эрхлэлтийг дэмжих, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэнэ.			
9	Орон нутгийн өмчийн газар	2022	Орон нутгийн өмч, хөрөнгийн үр ашиг сайжирсан байна, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангуулсан байна.	100%	155.2	155.2
10	Байгаль орчин аялал, жуулчлалын газар	2022	Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	100%	165.6	152.9
11	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ	2022	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зорилт хангагдсан байна.	82.9%	229.0	189.7
12	Цөм сүргийн үржлийн төв	2022	Сүмбэр үүлдрийн хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөж, каракуль хурганы арьсны чанарыг сайжруулан борлуулж төсвийн орлогын биелэлтийг хангуулна.	90%	148.8	127.7
13	Нийгмийн Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж	2022	Нийгмийн хамгааллын бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх	100%	38.5	20.5
14	Санхүүгийн хяналт аудитын алба	2022	Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийн байгууллагад нийтлэг илэрч буй зөрчлийг 2019 оны үзүүлэлтээс 10 хувь хүртэл бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгөх 2, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулж 90%-д хүргэх	100%	122.7	102.3
15	Сум дундын ойн анги	2022	Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ногоон байгууламжийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	100%	146.7	97.6
16	Насан туршийн боловсролын төв	2022	Насан туршийн боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах	100%	78.1	77.9
17	Биеийн тамир спортын газар, Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааны зардал	2022	Иргэдийн биеийн тамир, усан спортоор хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэн хэвийн үйл ажиллагааг хангана.	100%	290.4	289.5
18	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар, үйлчилгээний төлбөр	2022	Хууль, журамд нийцүүлэн байр ашиглалтын үйлчилгээг зохион байгуулсан байна.	100%	821.7	821.4
19	Мал эмнэлгийн вакцин	2022	Мал, амьтныг Зохих норм, хугацаанд вакцинд хамруулах	100%	7.9	7.9
20	Орон нутгийн хөгжлийн сан	2022	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хууль, журмын дагуу	92%	1,838.1	1,548.0
21	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2022	төлөвлөн хэрэгжилтийг хангах ажиллах	88.9%	3,587.8	2,411.0
Нийт				97.1%	11,493.5	9,385.6

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын Тамгын ХШҮХ-ийн тайлан)

4.2 ТЕЗ-ийн харьяанд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшнийг тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөж, хэрэгжилтийг бодитой үнэлэх шаардлагатай байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэн журам”-д заасан аргачлалын дагуу үнэлж дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

100 хувь буюу бүрэн хэрэгжсэн-15 хөтөлбөр

90 хувь буюу Гол үр дүн гарч эхэлсэн-5 хөтөлбөр

70 хувь буюу Гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн-1 хөтөлбөр

Үнэлгээнээс харахад хөтөлбөрийн үр дүнг зөвхөн санхүүжилтийг гүйцэтгэлд харьцуулан хувиар гаргаж үнэлсэн, чанарын үзүүлэлтээр үнэлээгүй нь тухайн хөтөлбөр арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхойгүй байна. Цаашид Төсөв захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн төлөвлөлтийг сайжруулах, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тоон болон чанарын утгаар илэрхийлэх, батлагдсан хөтөлбөрийг хугацаанд нь хэрэгжүүлж, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал:

Хяналт шинжилгээ үнэлгээний тайланд санхүүгийн үзүүлэлтийг шалгуур тогтоогоогүйгээс 21.1 сая төгрөгөөр орлого тасарсан, санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Цөм сүргийн үржлийн төвийг 90%-тай үнэлсэн нь үнэлгээ бодит бус байгааг харуулж байна. Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитын дүнгээр гүйцэтгэл 75.7 %-тай, зорилтот түвшиндээ хүрээгүй гэж үнэлсэн бол ХШҮ-ээр 88.9%-тай үнэлсэн нь бодит бус чанарын үзүүлэлтээр үнэлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар аймгийн Засаг даргын дэргэд Санхүүгийн хяналт, аудитын алба нь ТЕЗ-ийн батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 532.6 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

Төсвийн орлогын төлөвлөлт өмнөх жилүүдээс сайжирсан боловч зардлын төлөвлөлтөд тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжийг дагаж мөрдөөгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна.

1. ТЕЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжаар хориглосон “автомашин худалдан авах” арга хэмжээ төлөвлөсөн байна
2. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас хянасан хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна.

Бүлэг-2

Орлогын төлөвлөгөө дуудлага худалдааны орлогоос шалтгаалан нийт дүнгээрээ 5%-иар давж биелсэн байна.

1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 5% буюу 409.4 сая төгрөгөөр давж биелсэн боловч 9 нэр төрлийн татварын орлого 685.3 сая төгрөгөөр тасарсан байна
2. Хууль эрх зүйн үндэслэлгүй, тооцоо судалгаагүй 64.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн боловч огт орлого төвлөрүүлээгүй байна.
3. “Цөм сүргийн үржлийн төв”-ийн өөрийн орлогын төлөвлөгөө 21.1 сая төгрөгөөр тасарсан, зөрчил жил бүр давтагдсаар байна.
4. 2022 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 236.6 сая төгрөгөөр буурсан байна.
5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжсэн байна

Бүлэг-3

Төсвийн зарлагын гүйцэтгэл 85%-тай, нийт хэмнэлтийн 32 хувь буюу 941.3 сая төгрөгийн бодит бус хэмнэлт байна.

1. Аймгийн ЗДТГ, ИТХ-ын суурь зарлагыг төсвийн хязгаараас жил бүр нэмэгдүүлэн баталдаг, ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчил буурахгүй байгаа нь төсөв үр ашигтай зарцуулагдахгүй байгааг харуулж байна.
2. Төсвийн хэмнэлтийн 2,906.5 сая төгрөгийн 32 хувь буюу 941.3 сая төгрөг бодит бус хэмнэлт байна.
3. Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Бүлэг-4

Төсөв захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг чанарын үзүүлэлтээр үнэлээгүй байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 97.1 хувьтай байна.
2. ТЕЗ-ийн харьяанд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшнийг тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөж, хэрэгжилтийг бодитой үнэлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст

1. Татварын бус орлогыг үндэслэлтэй төлөвлөж, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, жил бүр татварын бус орлогын төлөвлөгөө тасарч байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
2. Сумдын төсөв батлах тогтоолыг хянах, үндсэн тэнцлийн ашиг болон, эхний үлдэгдлийг бүрэн батлахгүй байгаа зөрчлийн давтан гаргахгүй байх
3. Төсвийн зарлагын хязгаарын баримталж, шаардлагагүй урсгал зардлыг нэмж төлөвлөхгүй байх